

## Ц.Одгэрэл

МУИС-ийн НШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхмийн докторант

### БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТЭД ОРОЛЦООНЫ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ НЬ:

#### Нийгэм болон Жендэрийн тэгш байдалтай хамт авч үзэх нь

**Abstract:** The purpose of the research is to clarify the methods to provide gender equity in NRM on the basis of studying men and women's role and participation in NRM, and to identify the possibilities to support women's participation in NRM in the macro, mezzo, and micro levels of gender analysis. Women's participation in natural resource management, use, decision-making and implementation levels have been taken into consideration quite recently in Mongolia. Women's low participation in conservation, protection and restoration of natural resources and its management is matter of a reality today. The main sources of revenue of project activity implemented communities are pastoral animal husbandry. Although both women and men play important, but different roles in the management of natural resources in Mongolia's nomadic pastoralism, women's particular roles and participation in natural resource use, decision-making and implementation have been undervalued. In many cases, in research and in policy-making, women's knowledge and abilities are "simply" forgotten or neglected.

**Key words:** natural resource Management, participatory methodology, gender.

Хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр ажилладаг хүмүүс нийгмийн олон янзын үүрэг ролийг гүйцэтгэж байдаг. Нийгмийн олон янзын үүрэгт ихэвчлэн жижиг том фермерийн аж ахуйтнууд, үйлдвэр, компанийн бизнесмэнүүд, орон нутгийн засаг захиргааны эрх мэдэлтнүүд, нөөцөд тулгуурласан хэрэглэгч бүлгүүд, хамт олонд тулгуурласан байгууллага гэх зэрэг олон ялгаатай оролцогч талууд багтаж байдаг. Хөгжлийн санаачлага болон судалгаанд эдгээр ялгаатай хувь хүн, бүлгүүд нь өөр өөр мэдрэмж, мэдлэг, туршлага, сонирхолтойгоор нөөцийн менежментэд оролцдог. Тэд байгалийн нөөцийн менежментийн үйл явцын талаарх мэдлэг, шийдвэр гаргах, хяналт нь өөр өөр онцлог ялгаатай байдаг. Эдгээр оролцогч талууд нэг төрлийн биш эсвэл тогтсон бүлгүүд байдаггүй, харин нийгмийн зэрэг зиндааны хувьд жендэр, анги давхраа, угсаа гарал, нас зэрэг нийгмийн байдлаараа ялгаатай. Хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд судлаачид жендэрийн тэгш байдал, оролцоог бий болгох, хөгжүүлэх санаачлагуудыг гаргаж судалгаа хийхдээ дараах үзэл баримтлалуудыг авч үздэг.

- “Эмэгтэйчүүд хөгжилд –эмэгтэйчүүд тэгш эрх, ядуурлын эсрэг” /WID/
- “Эмэгтэйчүүд ба хөгжилд”-эмэгтэйчүүд өөрөө хөгжлийн түлхүүр гэж үзэх хандлага /WAD/
- “Жендэр ба хөгжил-эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөгжил дэх тэгш оролцоо /GAD/
- “Эмэгтэйчүүд, байгаль орчин ба хөгжлийн сонголтууд-Эрэгтэйчүүдийн тэргүүлэх оролцоо, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш бус оролцоо” /WED/
- “Постмодернизм ба хөгжил-хөгжиж буй орны эмэгтэйчүүдийн дуу хоолой, шийдвэр гаргахад тэгш оролцоо” /PAD/

Нийгмийн бүлгүүдийн хоорондын эрх мэдлийн харилцаанд жендэр, анги давхарга, үндэс угсаа асар их нөлөөлдөг ба хэн ой болон түүний бүтээгдэхүүнд хяналт тавих, хэн хамт олон, хамтлаг дахь усны нөөцөд менежмент хийх, хаана тариалан тарихыг хэн шийдэх гэх мэт олон асуудлыг байнга тодорхойлоход ч чухал байдаг. Ядуу бүлгийн хувьд нийгмийн, улс төрийн хувьд шоовдорлогдсон, үндэстний цөөнхийн хувьд экосистемийн болон нөөцийн менежментэд шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал оролцоотой байж нийгмээс гадуурхагддаг байна. Олон оронд эмэгтэйчүүд ихэвчлэн ядуу, нөөц баялаг өмчлөх эрх нь хязгаарлагдмал байдаг. Тэд байнга маш бага эсвэл огт ашиг хүртдэггүй. Гэсэн хэдий ч заримдаа тусгаарлагдсан бүлгүүдэд эмэгтэйчүүд багтдаг ч магадгүй үүнийг даван туулах чадвартай. Шийдвэр гаргах байр сууринд илүү эрх мэдэл оролцоотой ч байж болох юм. Жендэр нь ажил

хэрэгт хамаатай онцгой асуудал юм. Эрэгтэй эмэгтэйчүүд байгалийн нөөцөд ялгаатай үүрэг, харилцлагатай байхаас гадна хянах, үр нөлөөтэй оролцоход яаж оролцох нь бас хамаардаг байна.

Уламжлалт судалгаа болон хөгжлийн үйл ажиллагаанд байгалийн нөөцийн салбарт ядуучууд, эмэгтэйчүүд болон нийгмийн ядуу гадуурхагдсан бүлгийг хамруулдаггүй байсан. Эдгээр бүлгүүд нь судалгаа болон хөгжлийн үйл ажиллагаанаас ямар нэгэн ашиг хүртэгч байгаагүй юм. Судалгааны болон хөгжлийн үйл ажиллагааны шийдвэр гаргах, төлөвлөх үйл явцад жендэрийн үйл ажиллагааны дотор эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой болсныг зориуд тэмдэглэж байна.

***Оролцооны судалгаа болон байгалийн нөөцийн менежментэд нийгэм жендэрийн асуудал яагаад чухал вэ?***

Оролцооны судалгаа болон хөгжил нь нийгэм, эдийн засаг, экологийн үйл явцад нийгэм жендэрийн үүрэг роль, харилцааг ойлгох арга замыг ойлгоход туслах болно.

- Байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглахад хяналт тавих, нийгэм болон эрх мэдлийн харилцааны талаарх ухуулга сурталчилгаа, зөв ойлголтыг хөгжүүлэхэд
- Нийгэмд болон жендэржсэн бодлого, технологи, арга хэмжээг ойлгоход чиглүүлэх. Бодлого, технологид эрэгтэй эмэгтэйчүүдийг болон нийгмийн бусад бүлгүүдийг хамруулах
- Байгалийн нөөцийн менежментэд шоовдорлогдсон болон ялгаварлагдсан бүлгийн хүртэх үр өгөөж, оролцоо, эрх мэдлийг дэмжих, эрэгтэй эмэгтэйчүүдийн нийгмийн олон талд дүр үүрэг бүхий орон зайг бий болгох

**Үндсэн түлхүүр асуултууд:**

- Хамт олон болон бүс нутагт дахь байгалийн нөөцийн менежментэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн бий болгох, бүтээх зүйлийг ойлгох
- Нөөцийн менежмент болон ашиглалтанд нийгэм жендэрийн харилцааг тодорхойлох
- Шоовдорлогдсон бүлгийг байгалийн нөөцийн менежментэд оролцох оролцоог сайжруулах, оролцооны судалгаа гол чиглүүлэгчдийн үүргийг гүйцэтгэх

Судалгаа, хөгжлийн хөтөлбөрүүд, бодлого, арга хэмжээнээнд хэн оролцох, яаж оролцох, хэн ашиг хүртэх, ашиг хүртэхдээ яаж гэсэн асуулт хариултыг ойлгох хэрэгтэй болно.

***Оролцооны судалгааны хандлага болон жендэрийг дүн шинжилгээг байгалийн нөөцийн менежментэд ашиглах нь***

Оролцооны болон хөгжлийн судалгаа нь бэлчээр байгалийн нөөцөөс хүртэж байгаа үр ашиг, хяналт, оролцоо болон хамлаг дахь нийгэм болон эрх мэдлийн харилцааны төсөөтэй талын талаар судлаач, хамтлагийн гишүүдэд ойлголт өгөх, ухуулах ажлыг чиглүүлж байдаг. Ялангуяа оролцооны судалгааны гол хандлага нь хамтлагийн түвшинд ажиллаж, хэлэлцэх асуудлыг ярьж байгаагаараа онцлог юм. Гэхдээ хамгийн чухал нь хамт олон/хамтлаг бол нэг төрлийн зүйл биш, өөрөөр хэлбэл хамтлаг гэдэг бол өөрөө тийм ч ойлгомжтой ойлголт биш байдаг. Хамт олон/хамтлаг нь нийгмийн янз бүрийн хэсэг бүрдэл бүхий бүтэцтэй бөгөөд экосистемийн менежмент болон нөөц ашиглалтын талаар ялгаатай шийдвэр гаргах, нийгмийн болон эрх мэдлийн харилцааны хувьд ч ялгаатай удирдан зохион байгуулж байдаг. Энэ бол ялгаатай биеэ хүнээс бүтсэн нэгжүүд ба жинхэнэ эрхийн түвшинд байна. Байгалийн нөөцийн менежментийн олон судалгаанд нийгмийн асуудлыг ялангуяа үүрэг хариуцлага, хөдөлмөрийн хуваарилалт зэрэг жендэрийн асуудлыг онцгойлон авч үзэж анхаардаг.

Нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны үйл явцад нэгтгэх авч үзэх нь практикт тулгарч буй асуудлыг шийдэх, бэрхшээлтэй нөхцөл байдлаас гарах үйл ажиллагааны төлөвлөгөө/төсөл боловсруулахад ерөнхий, нэгдмэл дүр зураг гарган өгдгөөрөө чухал ач холбогдолтой. Гэхдээ нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны салшгүй нэг хэсэг болгох нь ярвигтай, хэцүү асуудал юм. Учир нь бараг бүх тохиолдолд жендэрийн дүн шинжилгээг зөвхөн оношлогооны түвшинд л хийж байна. Түүнчлэн ихэнхдээ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарийг дүрслэн үзүүлэхээс хэтэрч чадахгүй байна. Жендэрийн болон нийгмийн илүү чухал, ярвигтай харилцааны талаар шинжилгээ хийгдэхгүй байна. Үүний учир шалтгаан нь чадавхи хүрэлцэхгүй байгаагаас гадна олон нийт, хамт олон, байгууллага,

хувь хүмүүс, тэр ч байтугай судлаач нарын дунд ‘жендэрийн хараагүйдэл’ байгаа, жендэрийн асуудлыг ялган харж чадахгүй байгаатай холбоотой. Олон судлаач хүйсээс шалтгаалсан ялгаатай зорилго, төсөөлөл, үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрч, харгалзан үзэж тэр бүр чаддаггүй. Тэд нэг бол үл хайхардаг, эсвэл огт харалгүй орхигдуулдаг. Энэ бол нийгмийн болон жендэрийн дүн шинжилгээг судалгааны ертөнцөд нэгтгэн шингээхэд тохиолдож буй гол бэрхшээлүүдийн нэг билээ (Канадын олон улсын хөгжлийн судалгааны төв, 2004).

Нийгмийн ба жендэрийн асуудлыг хариуцдаг институцийн зохих бүтэц, байгууллага байхгүй байгаа нь судалгааны үйл явцад тулгарсан томоохон бэрхшээлийн нэг байв. Хөдөө аж ахуйн судалгаа, хөгжлийн байгууллагуудын зүгээс нийгмийн ба жендэрийн асуудлаар хийж буй ажил энд тэнд хуваагдан тархсан, зохих баримтжуулалт хийгдээгүй байна. Зөв хүнээ олж уулзах, хэрэгтэй бичиг баримтаа олоход цаг их зарцуулж байв.

*Оролцооны судалгааны хувьд нийгмийн олон үйлдэл бүхий дүр үүргийг гүйцэтгэдэг бүлгийн ялангуяа эдгээр дотроос нийгмийн орхигдсон бүлгийг хамруулах нь хамгийн чухал зорилго байдаг төдийгүй чухал ач холбогдолтой арга зам болно. Эдгээр бүлгийг оролцооны судалгааны загвар, хэрэгжилтэнд оролцуулах явдлыг санаачлах нь чухал. Ингэх нь тэдэнд дуу хоолойгоо илэрхийлэх, өөрийн гэсэн байр сууриа бий болгох гэсэн ач холбогдолтой.*

Байгалийн нөөцийг зохистой удирдан зохион байгуулах, нөөцийг зөв ашиглах арга замыг ойлгоход улирлын календари, өдөр тутмын үйл ажиллагааны график зэрэг хөдөөгийн оролцоотой судалгааны арга хэрэгслүүд байдаг. Гэсэн хэдий ч олон судлаачид энд зогсдог. Энэ аргаар эдгээр ялгаатай бүлгүүдийн хоорондын шийдвэр гаргах үйл явц дахь тэгш бус байдал, эрх мэдлийн харилцаа зэргийг ойлгоход туслдаг төдийгүй олон янзын ялгаатай бүлгүүдийн байгалийн нөөцийн менежментэд тулгарч байгаа бэрхшээл асуудлыг шийдэх, олон янзын бүлгүүдийн үзэл бодол, санааг нэгтгэхэд чухал ач холбогдолтой. Ялангуяа хэн шийдвэр гаргах вэ, хэзээ хэрхэн, хэн үр ашиг хүртэх вэ, хэрхэн яаж гэдэг асуудалд илүү анхаарал хандуулдагаараа онцлогтой.

Оролцооны хөгжлийн судалгаа нь оролцоо гэсэн нэр томъёог тодорхойлохдоо байгалийн нөөцийн менежментэд энэхүү ялгаатай оролцогч талуудыг хамруулах вэ гэдгийг авч үздэг. Эдгээр үйл явц шийдвэр гаргах үйл явцад ихэнхдээ орхигддог ядуу бүлгүүдийг оролцуулах боломжийг олгодог. Оролцоо гэдэг үг бол янз бүрийн бүлгүүдийн санаа бодлыг судалгааны бүхий л санаачлагын явцал оролцох боломжийг бий болгодог. Хэдий тий боловч энэ бол ямагт тохиолдлын төдий зүйл биш, оролцооны судалгаа ч жендэрийн мэдрэмжтэй эсвэл нийгмийн шударга байдлыг аяндаа бий болгох зүйл биш. Оролцоо бол нийгэм, хамт олны ойлголт, зарчмыг үргэлж хатуу баримталдаг төдийгүй оролцоо энэ хэм хэмжээ, дүрмээр зохицуулагдаж байдаг магадгүй нийгмийн бусад бүлгүүд болон ядуу эмэгтэйчүүдийн оролцоогоор тодорхойлогддог. Улс орон болон хамт олон, өрх дотор эрх мэдлийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцад ядуу бүлгээс хамаардаг байх, тэдэнтэй хэлэлцдэг байх явдал. Тэд төслийн үйл явцад оролцоог хангахад чухал үүрэгтэй төдийгүй асуудлыг шийдэхэд их тус дөхөм болдог.

Азид судалгааны болон чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаанаас суралцах сургамж. Канадын олон улсын хөгжлийн агентлаг

- **Байгалийн нөөцийн менежментийн судлаачдын дунд нийгмийн ухааны мэдлэг, туршлага хязгаарлагдмал байдаг.** Ерөнхийдөө байгалийн нөөцийн менежментийг судалдаг судлаачдын хувьд нийгэм жендэрийн дүн шинжилгээ хийх арга, арга зүй, энэ талын онолын үзэл баримтлалууд болон эдгээр арга хэрэгслэлүүдийг практикт хэрэглэх талаар бага мэдлэгтэй байдаг. Магадгүй хамтран оролцогч талууд анхан шатны ойлголттой байдаг ч судалгааны талбарт нийгэм, жендэрийн судалгааг хэрхэн хийх вэ, хэрхэн дүн шинжилгээ хийх талаар тийм ч сайн мэдлэгтэй биш, эргэлзсэн шинжтэй байдаг
- **Судалгаанд байгалийн ухааны болон нийгмийн ухааны мэдлэг салбаруудыг сайн нэгтгэж чаддаггүй.** Төслүүд нийгэм жендэрийн дүн шинжилгээг хийх асуудлыг багтаадаг, тэгвэл энэ асуудлаар байгалийн нөөцийн мэргэжилтнүүд бага ярилцдаг, бага хэлэлцдэг. Чухамдаа төслийн зөвхөн нэг, хоёр тусдаа хэсэг биш, хөгжлийн бүх үйл явц, арга хэмжээнд хэрхэн хэрэгжүүлснээс төслийн үр дүн хамаарч байдаг.
- **Хамтрагч талуудад нийгэм, жендэрийн асуудлаарх туршлага, сонирхол нь ялгаатай өөр мөн анхнаасаа ялгаатай олж авсан байдаг.** Бидний хэрэгцээ, арга

барил, асуудал нь өөр өөр байдаг тул ганц арга барилаар төсөөлөх нь учир дутагдалтай. Үүндээ бол өөр механизмаар, өөр дэмжлэг, сургалтаар энэхүү зорилгыг хангана.

- **Жендэрийн асуудалд сохороор хандах эсвэл жендэрийн асуудлыг нийтлэг мэдлэгээс татгалзах.** Олон судлаачид, хамтлагийн гишүүд, шийдвэр гаргагчид жендэрийн үзэл баримтлалын асуудалтай тулгарч байна. Жендэрийн асуудлыг зарим оролцогч талууд феминизмыг, барууны сонирхолоор удирдах гэсэн арга гэх зэргээр үл ойшоох, буруу ойлгох хандлага байдаг.
- **Богино хугацааны сургалтуудын үр нөлөө бага байдаг.** Нийгэм жендэрийн судалгаа, дүн шинжилгээний хөтөлбөрүүд нэг юмуу хэдэн долоо хоногийн хугацаатай богино хугацааны сургалтууд байдаг. Энэ нь хэдийгээр ашиг тустай ч судлаачид төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар үзэл бодол, хэрхэн тусламж дэмжих, юу хийхээ сайн төсөөлдөггүй. Энэ үйл хэрэгт урт хугацааны туршид хамтрагч нар болон дэмжлэг туслалцаа хэрэг болдог.
- **Хамгийн үр ашигтай зүйл бол хүчтэй сүлжээ байх.** Энэ нь судлаачид дуу хоолой, сонирхолоо илэрхийлэх, бусад судлаачдаасаа суралцах, ялангуяа бүс нутгийн талаар мэдэхэд их чухал. Судлаачдад нийгэм жендэрийн асуудлаар үзэл ойлголт, туршлагаа нэгтгэх, бие биенээсээ хамтдаа суралцах боломжийг бүрдүүлдэг.
- **Азид байгалийн нөөцийн менежментэд нийгэм жендэрийн судалгаа өргөн хүрээнд үр дүнтэй байж чадахгүй байна.** Азид ихэнх сургалтууд нийгэм жендэрийн судалгааны арга зүйн шинжтэй материал дээр түшиглэгдгээс бус шууд байгалийн нөөцийн менежментэд шууд тусч ажиллаж чадахгүй байна. Чухамдаа “Эмэгтэйчүүд ба хөгжил” гэсэн чухал асуудал одоо ч хэвээрээ байна. Энэ нь нийгэм соёлын ялгаатай байдал ч нөлөөлж байх талтай.


*Эх сурвалж: Роннеу Верной, Лиз Фабер, Бэлчээр БНМ-ийн судалгааг хийх нь: судлаачдад зориулсан чадавх бэхжүүлэх төслийн багц. 2005*

Оролцооны арга зүй, арга барилын талаарх жишээг тайлбарлах, үүндээ бол нийгмийн ялгаатай бүлэг, хамт олон, ялгаатай эрх мэдэл бүхий, эрх тэгш биш байдаг бүхий бүлэгт дэмжлэг үзүүлэх, ойлгуулах, удирдан чиглүүлэх, хэрэгжүүлэхийг талаар баримт жишээ юм. (Agarwal 2001, Cornwall, 2000) Зарим жишээ баримтуудад зөвхөн орон нутгийн удирдлагууд, элитүүдийг оролцуулахаас илүүтэйгээр ядуу, нийгмийн тусгаардагдсан бүлгүүдийг оролцооны хөгжлийн судалгаанд хамруулах тэдэнтэй холбоо тогтоох тухай авч үзсэн. Мөн судлаачид хамтлагийн эрэгтэйчүүдтэй уулзаж ярилцахыг урьтал болгодог мөн басхүү эмэгтэйчүүдийг оролцуулах, тэдэнтэй төслийн талаар ярилцах, төсөлд оролцуулах явдал ч чухал байна.

Олон төслүүд байгалийн нөөцийн менежментийн төсөл дэх оролцооны арга замаар эмэгтэйчүүдийг хамруулахад ихээхэн ач холбогдол өгөхийг чармайж байна. Зарим тохиолдолд ч төсөлд хамрагдах эмэгтэйчүүдийн тоо өсч байгаа, эмэгтэйчүүдэд чиглэсэн бичил үйл ажиллагаануудыг ч дэмжиж байгаа байж болох юм. Гэвч энэ бол үнэн хэрэгтээ оролцоог хангахын тулд гэсэн зорилгоор байж болохгүй юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд эмэгтэйчүүдтэй санал солилцох, ярилцах, ийм нөхцөл байдлыг бий болгоход нь тэдний сонирхол хүсэлд нь тулгуурлан дэмжлэг үзүүлэх тухай асуудал юм. Бас эмэгтэйчүүдийг оролцуулахад тэдэнд хүүхдээ асрах, гэрийн болон бусад ажил хөдөлмөрөө эрхлэх, эсвэл ямар нэгэн үйл ажиллагаанд оролцоход орон зайн хол байдал зэрэг нь эмэгтэйчүүдийн оролцоог хангахад хүндрэл учруулж байдаг. Эмэгтэйчүүдийг хурал ирэхийг урихад тэд дуу чимээгүй бүрэг байдаг тэдэнтэй дотно холбоо тогтоохын тулд цай, хүнс өгөх ч хэрэг гарч болно. Зарим эмэгтэйчүүд нээлттэй ярилцдаг, гэвч зарим лидер эрэгтэйчүүд түүнийг нь үл зөвшөөрдөг, асуудал шийдэхдээ авч үздэггүй. Ийм учраас эмэгтэйчүүд болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийг оролцооны хөгжлийн судалгаанд чухалчлан оролцуулах тэдний оролцоотойгоор орон нутгийн бүх асуудлыг шийддэг, хэлэлцдэг байхад илүү их анхаарал хандуулах хэрэгтэй болж байна.

Жишээ нь Матриц 1-т харуулснаар жендэрийн хувьд ядуу эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настнуудыг БНМ-ийн нэг гол оролцогч тал гэж үзэн тэдний мэдлэг туршлага, санаа бодлыг авч үзэж судалж байна.


**Матриц 1. БНМ-д оролцооны болон нийгэм жендэрийн судалгааг хийхдээ хамтлагийн түвшинд**



Оролцооны судалгааны үйл явц нь зөвхөн нийгмийн олон янзын дүр үүрэг бүхий хүмүүсийг оролцуулах явдлыг чиглүүлэхээс гадна нийгмийн олон янзын ялгаатай бүлгүүдийн үр нөлөөг ойлгож түүнд тохирсон бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх учиртай. Энэ бүх үйл явц, процесс нь оролцооны хяналт шинжилгээ үнэлгээнд тулгуурласан байхад чиглэгдэх бөгөөд ялангуяа нийгмийн ялгаатай бүлгүүдэд судалгааны үр дүнд тулгуурлан дэмжлэг үзүүлэх, дэмжих арга замыг эрэлхийлэхэд чиглэнэ.

**Хэн оролцох вэ?, хэрхэн, хэн шийдэх вэ?, хэн ашиг хүртэх вэ?**

Энэ асуултууд их энгийн ойлгомжтой мэт санагдаж магадгүй гэвч үүнийг оролцооны практикт эдгээр асуултууд нь өөрчлөлтийг авчрах юм. Судлаачид нийгмийн харилцаанд нийгэм соёл, улс төр эдийн засгийн гэх зэрэг бүх асуудлыг цогцоор нь гүн гүнзгий авч үзэж ажилладаг. Хөгжлийн судалгаанд үйл явцад ялгаатай асуудлуудад анхаарлаа хандуулдаг ба үүн дээр үндэслэн хэрхэн дэмжлэг үзүүлж болох эсэхийг ч судалдаг.



Судлаачид хамт олон, хамтлагуудаас хэнтэй ажиллах, дээрх асуултуудын талаар юу гэж бодож байгаа /хэн оролцох вэ, хэн ялж хэн үлдэж хоцрох вэ/, тэдэнд эдгээр асуудлыг шийдэхэд ямар стратеги, механизмыг хэрэгжүүлэх нь илүү сайн хувилбар байж болоход анхаарлаа хандуулдаг. Оролцооны арга барилын нэг онцлог зарчим нь эдгээр хөгжлийн зарчмыг хэрэгжүүлэхдээ “хамтдаа” гэсэн зарчим бөгөөд энэ нь бүх оролцогч талуудад, хамтлаг, хамт олонд асуудлыг зөв ойлгоход, өөрчлөлтийг чиглүүлэхэд ил тод байдлыг авчирдаг.

Оролцооны хөгжлийн судалгааны стратеги нь судалгаанд бүх ялгаатай оролцогч талуудыг оролцоог бий болгох боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Аль ч төсөл хөтөлбөрүүд нь нийгэм соёл, улс төрийн ялгаатай байдлыг авч үздэг үүн дээрээ үндэслэж стратегийг арга замаа боловсруулдаг. Гэхдээ бүх үйл явцад “бүгдээрээ” гэдэг зарчмыг баримтлан оролцооны судалгааны практикт оролцдог. Оролцооны үйл явц нь ялангуяа нийгмийн жендэрийн асуудал чухал байр суурь эзэлдэг, үүний тусламжтайгаар байгалийн нөөцийн менежментэд тусгаарлагдсан ядуу бүлгүүдийн үр ашиг хүртэх, оролцох, чадавх бэхжүүлэх, өөрчлөлт шинэчлэлтийг хийхэд тусламж үзүүлж чаддаг (Cornwall, 2000)

Байгалийн нөөцийн менежментийн судалгаанд оролцогч талуудаас хэн хамгийн түрүүнд нийгмийн янз бүрийн дүрд тоглогч оролцогч талууд, шийдвэр гаргач нар. Тэдний санал санаачлагыг судалгаагаар яаж дэмжих, ялангуяа хамт олон, хамтлагууд дахь гол тоглогчдыг илүү хүчтэй болгох улмаар тэгш байдлыг бий болгоход оролцооны судалгаа дэмжлэг болдог. Байгалийн нөөцийн менежментэд ялангуяа хөгжлийн судалгааны үйл туйлын зорилго нь талбар дахь үйл явдал. БНМ-д ч энэ асуудлыг өргөн хүрээтэйгээр авч үздэг. Энэ тохиолдолд оролцооны судалгаа нь ядуу бүлэгт орон зай өгөх, байгалийн нөөцийн менежментэд оролцуулах, амьжиргааны түвшинг улам сайжруулах, хөгжүүлэхэд оролцооны судалгаа нь боломж олгодог. Эрх мэдлийн болон нийгэм жэндэрийн тэгш бус байдалд өөрчлөлт гаргахад анхаарлаа хандуулах нь бас нэг арга. /Cornwall 2000, Sarah White's 1996/

#### Хүснэгт 1. Оролцогч талуудын оролцоо болон оролцооны арга барилын хэв маяг

Хэлбэр	Хэрэгжүүлэгч байгууллагуудын үндсэн үүрэг, оролцоо	Хүлээн авч байгаа оролцогчдын оролцоо	Оролцоо юунд зориулагдсан
Энгийн	Хууль- ямар нэгэн зүйл хийхийг харуулах	Потенциал үр ашгийг үнэлэх	Санаа бодлоо илэрхийлэх
Арга хэрэгслэл	Бүтээмж-төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, дэмжих	Үнэ өртөг-төсөлтэй холбоотой үйл ажиллагаа болон ажил хөдөлмөр, бусад үйл ажиллагаанд зарцуулах цаг	Үр дүн, хүрэх үр дүнгийн тооцоо болон орон нутгийн чиглүүлэгчид
Төлөөлөгч	Тогтвортой байдал-хараат байдлаас зайлсхийх	Хүрэх арга зам-төслийн хэлбэр агуулга, үр дүн болон удирдлага зохион байгуулалт	Орон нутгийн иргэдийн дуу хоолой тэдний хөгжил чадавхжилт
Өөрчлөгч	Эрх мэдэл, чадваржилт-шийдвэр гаргахад хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх	Эрх мэдэл- шийдвэр гаргах чадвар	Тогтвортой үргэлжлэх чанар

Хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн менежмент дэх оролцооны судалгааны гол ач холбогдол нь Засгий газар, санхүүжүүлэгч байгууллага болон нийгмийн олон ялгаатай үүрэг гүйцэтгэдэг бүлгүүд түүний дотроос ядуу бүлгийн оролцоог бий болгох, тэдний сайн сайхан байдлыг хангах, амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх улмаар байгалийн нөөцийн тогтвортой менежментэд оролцуулах боломжийг бий болгож байгаагаараа чухал. Энэ бүлэг нь нийгэмд, байгалийн нөөцийн менежментэд эрх мэдэл, чадвартай оролцох улмаар өөрчлөгдөх боломжийг бий болгож байгаа билээ.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежмент. 2010. Хамтын бүтээл. Эдмон хэвлэлийн компани. Улаанбаатар хот
2. Ронней Верной, Лиз Фабер. 2005. Бэлчээр БНМ-ийн судалгааг хийх нь: судлаачдад зориулсан чадавх бэхжүүлэх нь төслийн багц
3. Cornwall (2000) adapts Sarah White's (1996) Participatory Research and Development in Natural Resource Management: Towards Social and Gender Equity
4. Agarwal, B. 2001. Participatory Exclusions, Community Forestry and Gender: An Analysis for South Asia and a Conceptual Framework.
5. Cornwall, A. 2000. Making a Difference? Gender and Participatory Development. IDS Discussion Paper 378. Institute of Development Studies.
6. [www.research4development.info/./Brief1\\_Participatory\\_research\\_approaches.pdf](http://www.research4development.info/./Brief1_Participatory_research_approaches.pdf)